



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/347

Булган сум

Монгол Улсын Гавьяат тамирчин
Онолбаатарын Хуланд хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Баян-Агт сумын уугуул Монголын сагсан бөмбөгийн шигшээ багийн тамирчин 3x3 дэлхийн аваргын мөнгөн медальт Онолбаатарын Хуланд Монгол Улсын гавьяат тамирчин цол тэмдэг хүртсэн тул 20,000,000 (хорин сая) төгрөгийн хүндэтгэл үзүүлсүгэй.

2.Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг Аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн Булган аймаг, “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын 2026 онд хамтран ажиллах төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

